

УЛСЫН ШАЛГАЛТ - 2025

МОНГОЛ ХЭЛ IX АНГИ

“А” ХУВИЛБАР

80 МИНУТ

Аймаг/дүүрэг:

Сум:

Сургууль:

Анги:..... Бүлэг:

Овог:

Нэр:.....

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН 9 ДҮГЭЭР АНГИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ

“А” ХУВИЛБАР

80 МИНУТ

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР: Сонгох даалгавар бүр 2 оноотой.

Эрлэгийн данснаас хасагдчихсан амьтан

Яст мэлхий үүсээд хоёр зуу гаруй сая жил болж байна гэж үздэг. Дэлхий дээр мөнхийн гэмээр урт настай амьтан тун цөөн байдаг. Тэдний нэг нь яах аргагүй далайн яст мэлхий. Яст мэлхий 300-400 жил насалдаг болохыг эрдэмтэд хэдийнээ тогтоосон. Хоёр зуу насалж хогжруутай таягаа тулдаг “өвөө” нар олон бий. Яст мэлхийн урт насалдаг нууцыг эрдэмтэд олон жилийн турш судалж байна. Яст мэлхийг бүр үлэг гүрвэл бий болохоос өмнө үүссэн гэсэн таамаглал ч байдаг. Тэдний огт өөрчлөгддөггүй, хувьсдаггүй нь амьд организмын хувьд хачирхалтай үзэгдэл нь байгаль эх үнэхээр өөрийн зохицолдоогоор бүтээсэн мэт санагдана. Үүний дүнд хэд хэдэн дүгнэлт хийжээ. Тэдний амьдрал бүхэлдээ амар тайван, нам гүм орчинд өнгөрдөг. Байнга хөдлөөд, яваад байдаггүй яст мэлхийнүүд түм түжигнэсэн орчлонгоос ямагт хол байхыг хичээдэг байна. Нэг ёсондоо тэд ганцаардмал амьдралыг илүүд үздэг аж. Тиймдээ ч бодисын солилцоо нь бусад амьтныхаас хэд дахин удаан явагддаг нь урт наслах бас нэг нууц нь юм.

Мөн энэ амьтан өөрт хуримтлагдсан энергиэ хэмнэх онцгой чадвартай. Угаас тэд хоол хүнс голдоггүй. Голдуу өвс ургамал иддэг ч заримдаа усны амьтан зооглох нь бий. Яст мэлхийнүүд усанд ч хуурай газарт ч амьдарч чаддаг онцлогтой л доо. Тэдний дархлааны систем нь төрөл бүрийн халдвартай сайн тэмцэж чаддаг, гэмтэл шарх нь маш хурдан эдгэрдэг байна. Түүнчлэн амь бөхтэй амьтан.

Бас нэг сонирхолтой зүйл нь яст мэлхий зүрхний цохилтоо зогсоож, хэрэгтэй үед ажиллагаанд оруулж чаддаг. Зүрхээ зогсоосон яст мэлхий огт хөдөлдөггүй байна. Энэ үед яст мэлхийг яаж ч цочоосон огт хөдлөхгүй үхсэн мэт байдаг. Зүрхийг нь салгачхаад байхад хоёр өдрийн турш буюу 48 цаг зогсолтгүй цохилж чаддаг гайхамшигтай чадвартай ажээ. Түүний хуяг гайхалтай нууцлаг бөгөөд хэн хүний анхаарлыг байнга татдаг аж. Ялангуяа далайн яст мэлхийн хуяг хуурай газрынхаас бүр том, хоёр метр урт, 900 гаруй кг хүнд. Хэвлээр явагч энэ болхи амьтны хуягийн хэлбэр дүрс амьдралынх нь хэв маягаас шалтгаалан янз бүр байдаг. Тухайлбал: хуурай газрын яст мэлхийн хуяг босоо бол цэнгэг усных хавтгай хэлбэртэй. Хуяг нь түүний хэтэрхий зөөлөн арьсыг хамгаалах үүрэгтэй. Тийм ч учраас яст мэлхий айхаараа хуягтаа нуугддаг. Түүний хуяг нь дээд, доод хоёр хэсгээс бүтдэг бөгөөд хоорондоо ясаар холбогддог байна. Яст мэлхийн хуяг нь наслах тусам хатуурдаг гэдэг. Зарим үед яст мэлхийнүүд далай тэнгисээр хоол тэжээлгүй хэдэн зуун бээр аялах тохиолдол гардаг. Энэ үед тэд яг л өвөл ичээндээ орсон амьтан шиг юу ч идэлгүй олон хоногоор явна.

230 орчим төрлийн яст мэлхий манай дэлхийн тэнгис далай, хуурай газар аж төрдөг. Эдгээрийн дотроос аварга яст мэлхийтэй арай дотно танилцах хэрэгтэй юм. Аварга мэлхийнүүд Галапагосын арлуудад тархан амьдардаг. Энэ арал нь өмнөд Америкаас 1800 км зайд Атлантын далайд оршдог ажээ. Нуруун дээрх хуягийнх нь диаметр 1-1,5 метр хүртэл янз бүр байдаг. Жин нь 200-400 кг хүрнэ. Сарвуу нь булчинлаг бүдүүн хүчтэй. Араатнуудаас хуягаараа өөрийгөө хамгаалдаг байна. Яст мэлхий нь төдийлөн сайн сонсож чаддаггүй амьтан юм. Испанийн далайчид XVII зууны үед арлыг нээхдээ анх ийм амьтан байдгийг мэдсэн гэсэн. Хөргөгч нээгдээгүй, консерв хийгдээгүй байсан тэр цагт яст мэлхий хэмээх нь далайчдын аминд ордог хүнс байжээ. Даахаараа ачдаг байлаа. Хэчнээн сар жил болсон ч үхэхгүй. Үхэхгүй учир мах нь муудахгүй. Далайн дээрэмчид, халим агнагч нар яст мэлхийний хүчинд байнгын муудахгүй хоолтой болж. Түүнийг эрлэгийн данснаас хасагдсан амьтан гэж далайчид шоолцгоодог юм. Олон зуун жил энэ амьтныг хядсанаас болж одоо бараг устах дээрээ тулаад байгаа юм.

Ж.Мягмарсүрэн

1. Яст мэлхий урт насалдгийн шалтгаан нь юу вэ? /2 оноо/

А. Бодисын солилцоо нь бусад амьтныхаас хэд дахин удаан явагддаг.

Дорнод аймгийн Боловсролын газар

В. Яст мэлхийг бүр үлэг гүрвэл бий болохоос өмнө үүссэн гэсэн таамаглал ч байдаг.

С. Тэдний огт өөрчлөгддөггүй, хувьсдаггүй нь амьд организмын хувьд хачирхалтай үзэгдэл нь байгаль эх үнэхээр өөрийн зохицолдоогоор бүтээсэн мэт санагдана.

D. Түүнийг эрлэгийн данснаас хасагдсан амьтан гэж далайчид шоолцгоодог.

2. Эхийн сэдвийг зөв тодорхойлоорой. /2 оноо/

А. Яст мэлхий зүрхний цохилтоо зогсоодог тухай

В. Яст мэлхийнүүд усанд ч хуурай газарт ч амьдарч чаддаг тухай

С. Яст мэлхийн бие, физиологийн онцлогийн тухай

D. Яст мэлхийн амьдралын хэв маягийн тухай

3. Эхийн гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрийг олоорой. /2 оноо/

А. Бас нэг сонирхолтой зүйл нь яст мэлхий зүрхний цохилтоо зогсоож, хэрэгтэй үед ажиллагаанд оруулж чаддаг.

В. Эрлэгийн данснаас хасагдсан амьтан.

С. Тэдний дархлааны систем нь төрөл бүрийн халдвартай сайн тэмцэж чаддаг, гэмтэл шарх нь маш хурдан эдгэрдэг байна. Түүнчлэн амь бөхтэй амьтан.

D. Яст мэлхий нь төдийлөн сайн сонсож чаддаггүй амьтан юм.

4. “...Түүнчлэн амь бөхтэй амьтан.. ..” өгүүлбэрийн өнгө аясыг тодорхойлоорой. /2 оноо/

А. Баталсан өнгө аястай.

В. Бахархсан өнгө аястай.

С. Харамссан өнгө аястай.

D. Таамагласан өнгө аястай.

5.”...Олон зуун жил энэ амьтныг хядсана**аас** одоо бараг устах дээрээ тулаад байгаа юм...” өгүүлбэрийн “-аас” хэмээх онцолсон нөхцөлийг оновчтой солин найруулж, өгүүлбэрийн утгыг хадгалан бичихэд тохиромжтой холбоос аль нь вэ? /2 оноо/

A. -H

В. Агаад

C. тул

D. -вал

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР:

2.1. “Эрлэгийн данснаас хасагдчихсан амьтан” хэмээн нэрлэсний учрыг баримтад тулгуурлан 40-50 үгэнд багтаан дүгнэж бичээрэй. /5 оноо/

[illegible]

2.2 Д.Нямсүрэнгийн “Дөрвөн цаг” шүлгийн хэсгээс уншиж, кирилл бичигт хөрвүүлээрэй. /5 оноо/

1. Дорнод аймгийн Боловсролын газар
 2. Дорнод аймгийн Боловсролын газар
 3. Дорнод аймгийн Боловсролын газар
 4. Дорнод аймгийн Боловсролын газар
 5. Дорнод аймгийн Боловсролын газар
 6. Дорнод аймгийн Боловсролын газар
 7. Дорнод аймгийн Боловсролын газар
 8. Дорнод аймгийн Боловсролын газар
 9. Дорнод аймгийн Боловсролын газар
 10. Дорнод аймгийн Боловсролын газар

2.3 Эхийн найруулгын арга хэлбэрийг ашиглан “Монгол оронд ховордож буй амьтныг хамгаалахад бидний оролцоо” сэдвээр 180-200 үгэнд багтаан эх зохион бичээрэй. Бичихдээ дараах агуулгын бүтцийг ашиглаж болох юм./20 оноо/

- **Эхлэл хэсэг :** Монгол оронд нэн ховордож буй амьтны талаар мэдээлэл өгөх
- **Гол хэсэг:** Тухайн амьтны амьдралын онцлогийг баримтад үндэслэн бичих
- **Төгсгөл хэсэг :** Тухайн амьтныг хайрлан хамгаалах талаар өөрийн бодлыг бичиж төгсгөх

[illegible]

үгийн тоо (.....)

ҮНЭЛЭХ ХҮСНЭГТ:

[illegible]

Дорнод аймгийн Боловсролын газар

УЛСЫН ШАЛГАЛТ - 2025

МОНГОЛ ХЭЛ IX АНГИ

“В” ХУВИЛБАР

80 МИНУТ

Аймаг/дүүрэг:

Сум:

Сургууль:

Анги:..... Бүлэг:

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН 9 ДҮГЭЭР АНГИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ

“В” ХУВИЛБАР

ХУГАЦАА 80 МИНУТ

СОНГОХ ДААЛГАВАР

Сонгох даалгавар бүр 2 оноотой.

Халим хэмээх гайхамшиг

Сэтгүүлч Б.Батбилэг нэгэн сонирхолтой аялалд оролцсон юм. Аяллын нэр нь “Монгол Хемингуэй”. Тэрбээр Японы халим судлалын экспедицэд оролцож Номхон дөлгөөн далайд хэдэн сарын турш халимтай хөөцөлджээ. Энэ бол монгол хүний хувьд халимын араас явсан анхны тохиолдол байлаа. Б.Батбилэг аяллаас буцаж ирээд “Халим гэдэг амьтан чинь...” хэмээх бэсрэг ном бичжээ. Ном “гардуулах” үеэр аяллын тухай болон халимын талаар удтал хөөрөлдсөн нь мэдээж юм. Б.Батбилэгийн яриа, ном хоёр доорх найрууллын маань үндэс болсон билээ.

Далай тэнгисээс хол нутгийн монголчууд бид халимыг том биетэй загас гэж бодох нь олонтоо. Угтаа бол халим нь загас биш харин хөхтөн амьтан юм. Загалмайгаар амьсгалахгүй уушгиараа амьсгална. Түрс биш амьд зулзага төрүүлнэ. Түүнийгээ хөхөөрөө өсгөнө. Халимын өвөг дээдэс 55-65 сая жилийн өмнө хуурай газарт амьдарч байсан ноомой нэгэн “гөрөөчин” байжээ. Төрх нь чонорхуу юм. Манай дэлхий дээр олон галав юүлсэн гэдэг. Нэг удаагийн галав юүлэлтээр эх газар хувхайрчээ. Харин дэлхийн бөмбөрцгийн гуравны хоёрыг эзлэн цэлэлзэх далай тэнгис баян байлаа. Халиман чоно “Алтан загасны өвгөн” лугаа адил уснаас салахаа байлаа. Далай тэнгисийн нялцгай биетэн түүний хувьд хэнтэй ч булаацалдахгүй бэлэн хоол байсан юм. Сая сая жил өнгөрөхөд хөл нь бараг сэлүүр болж хувирлаа. Усанд амьсгаа авахгүйгээр гурав, дөрвөн минут, бүр гучин минут байж хоолоо олж чаддаг боллоо. Ийнхүү халим цэнхэр далайн сая сая жилийн бүтээгдэхүүн болон хөгжиж иржээ.

Одоо дэлхий дээр 80 гаруй зүйлийн халим амьдардаг байна. Далайн мандал дээр гарч ирээд усан хуй үлээж байгаа нь сүртэй гэж. Яг л орсон буур шиг. Хамгийн аварга нь цэнхэр халим. Нөгөөтэйгүүр цэнхэр халим манай дэлхийн хамгийн том амьтан юм. Биеийн урт нь 25-30 м, жин нь 90-120 тонн, зулзага нь 7-8 м урт, хоёр тонн орчим жинтэй төрдөг гэхчлэн гайхамшигт тоо цувруулж болох юм. Гэхдээ тоо заримдаа юуг ч илэрхийлж чаддаггүй. Халимын оврыг ерөнхийд нь ойлгуулах гэвэл гурван орцтой хоёр давхар орон сууцтай зүйрлэхэд дөхнө. Эсвэл түүний судсаар нь хүн хөвөөд явчхуйц гэж яривал илүү ойлгомжтой болох билээ. Халим ерөнхийдөө “Алатау” үүлдрийн үнээтэй төстэй, нуруугаараа бор саарал, хэвлийгээрээ цагаавтар өнгөтэй юм билээ. Цэнхэр халим уснаас гарч ирэхдээ цэнхэр туяа цацруулдаг учир ингэж нэрлэсэн болохоос цайвар саарал зүстэй амьтан ажээ.

Цэнхэр халим Номхон их далайд нүүдэллэн амьдардаг байна. Эрэгт бараг дөхдөггүй. Дулааны улиралд Мексикээс Хойд мөсөн далайн Чукотскийн тэнгис хүртэл аялан очиж үр зулзагаа гаргадаг байна. Халим ганц тугал гаргана. Чукотскад зуссан халим өвлийн эхээр зулзагаа дагуулсаар өмнөдийн дулаан тэнгис рүү 16-22 мянган км замыг туулан ирж өвөлждөг.

Хамгийн том амьтны идэш хариугүй бяцхан өт хорхой нялцгай биетэн байдаг нь хачирхалтай. Аварга халим далайн гүн рүү шумбаж байснаа эргэж дээшээ харна. Хэсэг өт хорхой олж дээш нь тууна. Тэд нь босож байгаа хуй шиг замдаа тааралдсан бүгдийг хаман өтгөрч дээшээ зугтсаар л байна. Мандал дээр гармагц нь устай юутай хээтэй нь залгиж орхино. Халим байсхийгээд л ус цацруулж эхэлдэг нь залгисан усаа хамрынхаа нүхээр гадагшлуулж буй хэрэг юм. Усаа цацруулж аманд үлдсэн хоолоо залгиж дууссаны дараа дахин гүн амьсгаа авч далайн гүнд шунгана. Халимын ходоод 2,5 тоннын багтаамжтай. Ийм ходоодыг өтөөр дүүргэх гэдэг маш их ажил болох нь ойлгомжтой. Халимууд цадсан үедээ далайн мандал дээгүүр умбан шумбан тоглодог.

Ертөнцөд найм дахь гайхамшиг гэж байдаг бол тэр нь лавтайяа халим байх биз. Хэчнээн эрхэмсэг тансаг амьтан гэж бодно. Цэвэрхэн, тайван амгалан, энэ их далайн эзэн нь би гэх шиг. Бас "Цэнхэр гүнж" гэж өхөөрдөх нь ч бий. Тун оносон нэр шүү. Тийм

Дорнод аймгийн Боловсролын газар

л гоёмсог сайхан амьтан даа. Цэнхэр их далайдаа амгалан тайвнаар хөвсөөр л. Халим маш сайхан дуу гаргадаг амьтан. Буга урамдаж байгаа юм шиг авиа гаргадаг. Тэр нь нэлээд алсаас дуулдана.

Ертөнцөд найм дахь гайхамшиг гэж байдаг бол тэр нь лавтайяа халим байх биз.

Их далайд хүнээс өөр дайсангүй жаргалтай. Тэрхүү сансар мэт уудам усан огторгуйд хүн ч юу гэж үзэгдэх вэ? Сүрэглэн хөөцөлдөнө. Зулзагаа нуруундаа үүрч эрхлүүлнэ. Дээшээ харвал гэдсэн дээр нь, доошоо харвал нуруун дээр чаргуулдаастай. Эхээс өдөрт 100 литр сүү гарах чадвартай гэсэн. Дээр хөх тэнгэр мэлтийж, доор хөх далай цахарна. Урт насалж удаан жаргана. Гэвч бас нэг зовлон байдгийг мартчихаж. Хааяа өвчин тусна. Давхисаар байгаад эдгээнэ. Хүндэрсэн юм уу шархадсан нэгнээ хоёр талаас нь ээлжлэн өргөж уснаас цухуйлган амьсгалуулдаг ажээ. Эдгэршгүй халдварт өвчин тусвал яах вэ? Шинэ Зеландад 46 эм, 13 эр халим далайн эрэг дээр гэнэт гарч ирээд байсан тохиолдол дэлхий нийтийг шуугиулж байсан цаг саяхан. Иймэрхүү жишээ зөндөө байдаг байна. Чухам юунаас болж ингэж амиа хорлох болов? Олон тайлбар байдаг. Хамгийн үнэнд ойр нь “сүрэгт халдварт өвчин гарсан тул” хэмээх тайлбар юм. Өвчилсөн халимнууд нэгэнт эдгэрэхгүйгээ мэдэрснээс бусдадаа халдаахгүйн тулд далайн хөвөө зорьдог байна. Далайн ус халдварт өвчнийг агаараас дутахгүй тархаадаг гэнэ.

Ж. Мягмарсүрэн

1. Халимнууд далайн хөвөө зорьдог шалтгаан нь юу вэ? /2 оноо/

- A. Далай тэнгисийн нялцгай биетэнг хэнтэй ч булаацалдахгүй идэх гэж зорьдог.
- B. Далайн мандал дээр усан хуй үлээх гэж далайн хөвөөнд гарч ирдэг.
- C. Өвчилсөн халимнууд өвчнөө бусдадаа халдаахгүйн тулд далайн хөвөө зорьдог.
- D. Загалмайгаар амьсгалахгүй уушгиараа амьсгалахын тулд далайн хөвөөнд ирдэг.

2. Эхийн сэдвийг зөв тодорхойлоорой. /2оноо/

- A. Далайн тэнгис дэх содон амьтны тухай
- B. Далайн халимын үүсэл гарлын тухай
- C. Халим махчин амьтан болох тухай
- D. Халим судалгааны тухай

3. Эхийн гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрийг олоорой. /2 оноо/

- A. Цэнхэр халим манай дэлхийн хамгийн том амьтан юм.
- B. Халим нь загас биш харин хөхтөн амьтан юм.
- C. Ертөнцөд найм дахь гайхамшиг гэж байдаг бол тэр нь лавтайяа халим
- D. Халим цэнхэр далайн сая сая жилийн бүтээгдэхүүн болон хөгжиж иржээ.

4. “... Ертөнцөд найм дахь гайхамшиг гэж байдаг бол тэр нь лавтайяа халим байх биз гэсэн өгүүлбэрийн өнгө аясыг тодорхойлоорой. /2 оноо/

- A. Баталсан өнгө аястай
- B. Таамагласан өнгө аястай
- C. Бахархсан өнгө аястай
- D. Харамссан өнгө аястай

5. “...Халим уснаас гарч ирэхдээ цэнхэр туяа цацруулдаг **учир** цэнхэр халим гэж нэрлэдэг гэнэ” гэсэн өгүүлбэрийн онцолсон холбох үгийг оновчтой солин найруулж, өгүүлбэрийн утгыг хадгалан бичихэд тохиромжтой холбоос аль нь вэ? /2 оноо/

- A. тул
- B. бөгөөд
- C. -магц
- D. үед

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР

2.1. “Цэнхэр гүнж” хэмээн нэрлэсний учрыг баримтад тулгуурлан 40-50 үгэнд багтаан тайлбарлан бичээрэй. /5 оноо/

.....

.....

.....

.....

.....

2.2. Д.Нямсүрэнгийн “Дөрвөн цаг” шүлгийн хэсгээс уншиж, кирилл бичигт хөрвүүлээрэй.

/5 оноо/

Монгол оронд ховордож буй амьтныг хамгаалахад
бидний оролцоо
Монгол оронд ховордож буй амьтныг хамгаалахад
бидний оролцоо
Монгол оронд ховордож буй амьтныг хамгаалахад
бидний оролцоо

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

2.3. Эхийн найруулгын арга хэлбэрийг ашиглан “Монгол оронд ховордож буй амьтныг хамгаалахад бидний оролцоо” сэдвээр 180-200 үгэнд багтаан эх зохион бичээрэй. Бичихдээ дараах агуулгын бүтцийг ашиглаж болох юм. /20 оноо/

- Эхлэл хэсэг : Монгол оронд нэн ховордож буй амьтны талаар мэдээлэл өгөх
- Гол хэсэг: Тухайн амьтны амьдралын онцлогийг баримтад үндэслэн бичих
- Төгсгөл хэсэг : Тухайн амьтныг хайрлан хамгаалах талаар өөрийн бодлыг бичиж төгсгөх

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

ҮНЭЛЭХ ХҮСНЭГТ:

[illegible]/ /
/ /